

ТАНИЛЦУУЛГА

Өрсөлдөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн талаар

Монгол Улсад анх Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хууль 1993 онд батлагдаж, 2010 онд хуулийн шинэчилсэн найруулга болох Өрсөлдөөний тухай хуулийг баталсан нь өнөөдрийг хүртэл хүчин төгөлдөр үйлчилж байна.

Монгол Улсын Их хурлын 2017 оны 11 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 22-т “Өрсөлдөөний тухай хуулийг хэрэгжүүлэх явцад тулгамдаж байгаа бэрхшээлийг шийдвэрлэх, уг хуулийг зах зээлийн эдийн засгийн харилцааг зохицуулах суурь хууль болгон өөрчлөн шинэчлэх” гэж, Монгол Улсын Их Хурлын 2016 оны 45 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 2.13-т “Зах зээл дэх шударга өрсөлдөөнийг дэмжиж, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах хууль, эрх зүйн орчинг сайжруулна” гэж тус тус заасан.

Мөн Олон Улсын Валютын сангаас Монгол Улстай хамтран хэрэгжүүлж байгаа “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийн хүрээнд Дэлхийн банк, Япон улсын “ЖАЙКА” байгууллагаас хамтран хэрэгжүүлэх Эдийн засгийн бодлогын удирдлагыг дэмжих хөгжлийн зээлийн матриц”-ын 3.55-д “Өрсөлдөөний тухай хуулийг шинэчлэн найруулах, хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх” гэж Монгол Улсын Засгийн газар тодорхой үүрэг хүлээсэн байна.

Өрсөлдөөний тухай хуулийг хэрэгжүүлэх явцад тулгамдаж байгаа бэрхшээлийг шийдвэрлэх, хууль хоорондын зөрчил, хийдлийг арилгах, нэг мөр ойлгомжтой болгох, олон улсын тэргүүн туршлагыг нэвтрүүлэх, орхигдуулсан зарим зохицуулалтыг бий болгох зэргээр өөрчлөн сайжруулж, цаг үетэй нь нийцүүлэх, түүнчлэн шинээр мөрдөгдөж эхэлсэн Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн үзэл баримтлал, зохицуулалтын ерөнхий чиглэлд нийцүүлэн хуулийн төсөлд өрсөлдөөний чиглэлээр хийгдэх үндсэн чиг үүргийн хяналт шалгалтын зохицуулалтыг зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанаас тусад нь зааглан тодорхойлох замаар хуулийн төслийг боловсрууллаа.

Хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу түүнд нийцүүлэн боловсруулсан бөгөөд мөн Японы Олон Улсын хамтын ажиллагааны байгууллага “ЖАЙКА”-тай хамтран хэрэгжүүлжсэн “Монгол Улсын шударга өрсөлдөөний орчинг бэхжүүлэх нь” төслийн хүрээнд хийгдсэн “Монгол Улсын өрсөлдөөний хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох нь” сэдэвт 4 удаагийн цуврал хэлэлцүүлэг, судалгааны ажлуудаас гарсан санал, зөвлөмж, гадаад орнуудын өрсөлдөөний байгууллага, мэргэжлийн экспертүүдийн өгсөн зөвлөмжид үндэслэн боловсруулсан.

Мөн Өрсөлдөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу үр нөлөөний үнэлгээг хуулийн төсөл боловсруулах туршлага бүхий мэргэжилтнээр хийлгэж, уг үнэлгээний тайлангаас гарсан санал зөвлөмжийн дагуу хуулийн төсөлд холбогдох өөрчлөлтүүдийг оруулан эцэслэн боловсруулсан болно.

Хуулийн төсөл бүтцийн хувьд 5 бүлэг 31 зүйлтэй бөгөөд зохицуулалтын хувьд өрсөлдөөний хяналт, зохицуулалтын гол асуудлууд болох давамгайл, зүй ёсны монополь байдалтай аж ахуйн нэгжүүдийн зохицуулалт, аж ахуй эрхлэгчдийн нэгдэх,

нийлэх, хувьцаа худалдан авах үйл ажиллагаанд хийх өрсөлдөөний зохицуулалт, өрсөлдөөнийг хязгаарлахад чиглэсэн гэрээ хэлцлийн хяналт зохицуулалт, өрсөлдөөнийг хязгаарлах бусад үйл ажиллагааны зохицуулалт, түүнчлэн өрсөлдөөний асуудал эрхэлсэн төрийн байгууллагын бие даасан байдлыг баталгаажуулах, хамтын удирдлагын зарчмаар ажиллах, оновчтой бүтэц зохион байгуулалттайгаар ажиллах тогтолцоог төгөлдөржүүлэх зэрэг зохицуулалтыг хуулийн төсөлд тусгалаа. Тухайлбал,

1. Өрсөлдөөний тухай хуулийн хүрээнд хийсэн хяналт шалгалт, зөрчил шалган шийдвэрлэсэн үр дүнгийн талаар эцсийн шийдвэрийг улсын байцаагч дангаараа гаргаж уг шийдвэрийг холбогдогч этгээд эс зөвшөөрвөл шууд шүүхэд гомдол гаргаж байгаа өнөөгийн тогтолцоо учир дутагдалтай байна гэж үзэж байгаа.

Учир нь ямар нэг байгууллага, албан тушаалтны гаргасан шийдвэр, тэр тусмаа шийтгэл оногдуулах эсэх талаар гаргасан шийдвэрт гаргасан гомдлыг тухайн албан тушаалтны дээд шатны байгууллага, албан тушаалтан шүүхийн өмнөх шатанд хянаж үзэн албан тушаалтны шийдвэрийг хуульд нийцэж байгаа эсэх талаар шийдвэр гаргадаг байх нь оновчтой юм. Өрсөлдөөний асуудлаар гаргасан шийдвэр бүрт холбогдогч этгээд ямар нэг хэлбэрээр гомдол гаргах нь гарцаагүй байдаг тул шүүхийн өмнөх шатанд урьдчилан шийдвэрлэх ажиллагаа явуулдаг байх нь шүүхийн ачааллыг ч бууруулах ач холбогдолтой юм.

Тиймээс өрсөлдөөний асуудлаар хийгдсэн хяналт шалгалт, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаатай холбоотой асуудлаар гаргасан улсын байцаагчийн шийдвэрийг эс зөвшөөрч гаргасан гомдлыг өрсөлдөөний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага шүүхийн өмнөх шатанд урьдчилан хянан шийдвэрлэдэг байхаар хуулийн төсөлд тусгалаа.

2. Захиргааны ерөнхий хууль, Зөрчлийн тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль батлагдсантай холбоотой хууль хоорондын уялдааг хангах, хийдлийг арилгах шаардлагатай байгаа. Тухайлбал: Өрсөлдөөний тухай хуулийн 13 дугаар зүйлд төрийн захиргааны байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллагаас өрсөлдөөнд харш үйл ажиллагаа явуулахыг хориглосон зохицуулалт байдаг. Гэтэл Захиргааны ерөнхий хуулийн 5 дугаар зүйлд "захиргааны байгууллага"-ыг тодорхойлсон нь Өрсөлдөөний тухай хуулийн 13 дугаар зүйлд зааснаас илүү өргөн хүрээтэй байна. Өөрөөр хэлбэл Өрсөлдөөний тухай хууль нь "захиргааны байгууллага"-ыг Захиргааны ерөнхий хуульд зааснаас зөрүүтэйгээр тодорхойлсон тул өрсөлдөөнд нөлөөлөхүйц шийдвэр гаргах боломжтой "захиргааны байгууллага"-ыг Захиргааны ерөнхий хуульд нийцүүлэн томъёолж хуулийн төсөлд тусгасан.

Түүнчлэн Өрсөлдөөний тухай хууль зөрчсөн асуудлаар зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулж болох хөөн хэлэлцэх хугацааг өрсөлдөөний зөрчлийн онцлогт нийцүүлэн Зөрчлийн тухай хуульд заасан нийтлэг хөөн хэлэлцэх хугацаанаас өөр байхаар хуулийн төсөлд тусгалаа.

Мөн Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн үзэл баримтлал, зохицуулалтын ерөнхий чиглэлд нийцүүлэн өрсөлдөөний чиглэлээр хийгдэх үндсэн чиг үүргийн хяналт шалгалтын зохицуулалтыг зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанаас тусад нь байхаар зааглан тодорхойлж хуулийн төсөлд тусгалаа.

3. Өнөөдрийн байдлаар Өрсөлдөөний тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах байгууллага нь хамтын удирдлагын зарчмаар ажиллахаар Өрсөлдөөний тухай хуульд тусгагдсан боловч байгууллагын оноосон нэрийг Шударга өрсөлдөөн,

хэрэглэгчийн төлөө газар гэж хуульд зааж өгсөн байдаг. Үүнээс үүдэлтэйгээр уг байгууллага хамтын удирдлагын зарчмаар ажилладаг эсэх нь нийтэд ойлгомжгүй байдгаас гадна байгууллагын дарга, гишүүдийн бүрэн эрх, түүнийгээ хэрэгжүүлэх байдалд мөн тодорхойгүй байдлууд багагүй үүсдэг.

Олон улсын жишигт төдийгүй Монгол Улсад хамтын удирдлагын зарчмаар ажилладаг байгууллагууд нь хороо, комисс гэсэн нэршилтэй байдаг нийтлэг жишигтэй. Жишээлбэл Санхүүгийн зохицуулах хороо, Эрчим хүчний зохицуулах хороо, Сонгуулийн ерөнхий хороо, Харилцаа холбооны зохицуулах хороо, Хүний эрхийн Үндэсний комисс гэх мэт.

Мөн Өрсөлдөөний тухай хуульд уг хуулийн хэрэгжилтэд хяналт тавих байгууллага нь улсын хэмжээнд хуулийн хэрэгжилтийг хангуулж, мөн өрсөлдөөний бодлогыг улсын хэмжээнд хэрэгжүүлэх бүрэн эрхтэй байхаар заасан боловч орон нутагт салбар нэгж байхгүйн улмаас бодлогын болон хуулийн хэрэгжилт сул байгаа.

Тиймээс өрсөлдөөний асуудал эрхэлсэн төрийн байгууллагын оноосон нэрийг "Хороо" гэсэн тодотголтой байхаар мөн орон нутагт улсын байцаагч ажиллахаар хуулийн төсөлд тусгасан. Хороо нь хамтын шийдвэр гаргах субъект бөгөөд энэ утгаараа гаргаж байгаа шийдвэр нь бодит байдалд нийцсэн, нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн байж чаддаг. Зах зээлийн өрсөлдөөний зохицуулалт нь аж ахуй эрхлэгчдийн хувийн өмч, бизнесийн нэр хүнд, ашиг орлогын асуудалтай шууд холбогддог гэдэг утгаараа үнэн бодитой, хуульд нийцсэн шийдвэр гаргахыг шаарддаг онцлогтой юм.

Хуулийн төслийн нэгдүгээр бүлэгт: Хуулийн зохицуулалттай холбоотой нийтлэг харилцааг тусгасан бөгөөд одоо мөрдөж байгаа Өрсөлдөөний тухай хуулиас дараахь байдлаар өөрчлөгдсөн. Үүнд:

1. Монгол Улсын нийт нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуй эрхлэгч, Захиргааны ерөнхий хуулиар тодорхойлсон захиргааны бүх байгууллага хуулийн үйлчлэлд хамаарч байгаа болно.

2. Хуулийн нэр томъёоны хувьд өмнөх хуульд байсан оновчтой бус нэр томъёог боловсронгуй болгосон.

Хуулийн төслийн хоёрдугаар бүлэгт:

Уг бүлэгт өрсөлдөөний асуудлаар хийгдэх гол зохицуулалтыг заасан бөгөөд одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа Өрсөлдөөний тухай хуульд заасан энэ талаархи зохицуулалт үндсэндээ хэвээр хадгалагдаж зарим нэг нэр томъёо, ойлголтыг илүү боловсронгуй, ойлгомжтой, хоёрдмол утга санаагүй нэг мөр байхаар төсөлд тусгасан.

Энэ бүлэгт тусгасан зохицуулалтаас одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа Өрсөлдөөний тухай хуулиас зарчмын хувьд өөрчлөгдөн тусгагдсан зарим зохицуулалтыг дурдвал:

1. Хуулийн төсөлд зах зээлд давамгайл байдалтай аж ахуй эрхлэгчийг урьдчилан судалж тогтоодог өнөөгийн зохицуулалтыг өөрчилж ямар ч аж ахуй эрхлэгчийг аль нэг зах зээлд давамгайл байдалтай эсэхийг урьдчилан судалж тогтоох шаардлагагүй байхаар тусгасан. Учир нь үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуй эрхлэгч бүрийг холбогдох бүх зах зээлд нь ямар хувь эзэлж байгааг, давамгайл байдалтай байгаа эсэхийг судалж тогтоох, зах зээлийн өөрчлөлт бүрийг тухай бүр судалж байх нь цаг

хугацаа, хүн хүчний хувьд бараг боломжгүй зүйл юм. Одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа Өрсөлдөөний хуулиар зах зээлд давамгай байдалтай аж ахуй эрхлэгчийг урьдчилан судалж тогтоодог байхаар зааж зохицуулснаас үүдэлтэй бодит байдал дээр хуулийн хийдэл ихээхэн гарч байгаа. Өөрөөр хэлбэл бодит байдал дээр давамгай байдалтай аж ахуй эрхлэгчийг давамгай байдалтайгаар урьдчилан тогтоож нийтэд зарлаагүй л бол уг аж ахуй эрхлэгч хууль зөрчсөн байсан ч шийтгэл хүлээхгүй байх тохиолдол гарч байна.

Хуулийн төсөлд тусгаснаар дээрх хуулийн хийдэл бүрэн арилах бөгөөд аль нэг аж ахуй эрхлэгч хуульд заасан тодорхой зөрчлийг гаргасан бол уг этгээдийг зөрчил үйлдэх үедээ давамгай байдалтай байсан эсэхийг судалж тогтоон хуулийн үйлчлэлд хамаарах эсэхийг шийдвэрлэдэг болно. Энэ нь олон улсад мөрдөгддөг зохицуулалтын нийтлэг жишиг төдийгүй бодит байдалд үр дүнтэй хэрэгжих бүрэн боломжтой.

2. Хуулийн төсөлд одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа Өрсөлдөөний тухай хуульд заасан аж ахуй эрхлэгчдийн нэгдэх, нийлэх, хувьцаа худалдан авах харилцааны зохицуулалтыг илүү боловсронгуй, хэрэгжихүйц байхаар, мөн олон улсын жишигт нийцүүлэн тусгасан.

Ингэхдээ аж ахуй эрхлэгчдийн нэгдэх, нийлэх, хувьцаа худалдан авах харилцаанд хийх өрсөлдөөний зохицуулалтад хамаарах аж ахуй эрхлэгчдийн талаар босго борлуулалтын орлогын хэмжээг Засгийн газраас тогтоодог байхаар хуулийн төсөлд тусгасан. Мөн зарим зохицуулалтын хүрээг багасгаж өгсөн нь аж ахуй эрхлэгчдэд таатай нөхцөлийг бий болгоно.

Одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа Өрсөлдөөний тухай хуульд заасан энэ төрлийн зохицуулалтад зөвхөн давамгай байдалтай аж ахуй эрхлэгч хамаарахаар байгаа нь нэгдүгээрт давамгай байдалтайгаар урьдчилж тогтоогдоогүй этгээд уг зохицуулалтад хамаарахгүй болох, хоёрдугаарт, давамгай биш хэд хэдэн этгээд нэгдэх, нийлэх замаар зах зээлд хэт төвлөрөл үүсгэж өрсөлдөөнийг хязгаарлах боломжийг олгож байгаа.

Хуулийн төсөлд тусгаснаар одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа Өрсөлдөөний тухай хуульд байгаа дээрх хийдэл бүрэн арилна.

3. Уг бүлэгт заасан өрсөлдөөнийг хязгаарлах бусад үйл ажиллагааны зохицуулалт буюу бүх аж ахуй эрхлэгчдэд хамаарах зохицуулалт нь одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа Өрсөлдөөний тухай хуульд байгаа зохицуулалтыг агуулгын хувьд хэвээр хадгалсан бөгөөд хууль хэрэглээний явцад үүсч байгаа зарим нэг тодорхой бус, хоёрдмол утга агуулгатай ойлголтыг нэг мөр болгож, мөн өрсөлдөөний харилцаанд хамаарахгүй оюуны өмчийн эрхийг хамгаалах асуудлын хүрээнд зохицуулагдах зарим зохицуулалтыг өөрчилж хуулийн төсөлд тусгасан.

Хуулийн төслийн гуравдугаар бүлэгт

Энэ бүлэгт тусгасан зохицуулалт нь одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа Өрсөлдөөний тухай хуульд заасан зохицуулалтыг үндсэнд нь хэвээр хадгалж байгаа бөгөөд өөрчлөлт орж байгаа гол зүйл нь хуулийн хэрэгжилтэд хяналт тавих байгууллагын оноосон нэрийг “Хороо” гэсэн тодотголтой байхаар хуулийн төсөлд тусгаж хорооны болон даргын бүрэн эрх, дарга, гишүүдийг томилох, чөлөөлөх асуудлыг илүү тодорхой тусгалаа.

Учир нь одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа Өрсөлдөөний тухай хуульд уг хуулийн хэрэгжилтэд хяналт тавих байгууллагыг хамтын удирдлагын зарчмаар ажиллахаар зааж зохицуулсан боловч оноосон нэрийг хуульд Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар гэж зааж өгсөн нь бусдад хамтын удирдлагын зарчмаар ажилладаг гэх ойлголтыг шууд илэрхийлж чаддаггүй бөгөөд цаашлаад уг байгууллагын орон тооны болоод орон тооны бус гишүүд чиг үүргээ хэрэгжүүлж ажиллахад олон нийтэд төдийгүй төрийн байгууллагын түвшинд ч үл ойлгогдох байдал байнга үүсдэг байна.

Мөн Өрсөлдөөний тухай хуульд зааснаар Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар өрсөлдөөний бодлогыг улсын хэмжээнд хэрэгжүүлэх, хуулийн хэрэгжилтийг улсын хэмжээнд зохион байгуулахаар тусгасан байдаг. Гэвч энэ байгууллага өнөөдрийн байдлаар Улаанбаатар хотод 36 алба хаагчийн орон тоотой¹, орон нутагт ямар ч салбар нэгжгүй ажиллаж байна.

Анх 2004 онд Засгийн газрын 222 дугаар тогтоолоор Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрыг байгуулахдаа 33 алба хаагчийн орон тоотой ажиллуулахаар байгуулж байсан бөгөөд тухайн үед энэ байгууллага нь зөвхөн Өрсөлдөөний тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах чиг үүрэгтэй байсан. Гэтэл 2008 онд Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль, 2010 онд Зар сурталчилгааны тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулиудын хэрэгжилтэд хяналт тавих чиг үүргийг уг байгууллагад нэмж хүлээлгэсэн боловч орон тоо, төсвийг огт нэмэлгүйгээр ажиллуулж ирсэн.

Үүнээс болоод Өрсөлдөөний тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах, өрсөлдөөний талаар төрөөс баримтлах бодлого боловсруулж шийдвэрлүүлэх, уг бодлогыг улс орон даяар хэрэгжүүлэх ажилд хүн хүч дутагдаж, хуулийн хэрэгжилт сул байх нөхцөл бүрдсэн байна.

Иймээс хуулийн төсөлд өрсөлдөөний асуудал эрхэлсэн төрийн байгууллагын бүтцийг хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэх боломжтой байхаар боловсронгуй болгох зохицуулалтыг тусгалаа.

Хуулийн төслийн дөрөвдүгээр бүлэгт:

Хуулийн төслийн энэ бүлэгт одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа Өрсөлдөөний тухай хуулиас ялгаатай тусгагдсан зүйл нь Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн үзэл баримтлал, зохицуулалтын ерөнхий чиглэлтэй уялдуулан өрсөлдөөний чиглэлээр хийгдэх үндсэн чиг үүргийн хяналт шалгалтын зохицуулалтыг зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанаас тусад нь байхаар зааглан тодорхойлж хяналт шалгалтын ажиллагаатай холбоотой зохицуулалтыг тусгалаа.

Мөн өрсөлдөөний асуудлаар хийгдсэн хяналт шалгалт, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаатай холбоотой асуудлаар гаргасан улсын байцаагчийн шийдвэрийг эс зөвшөөрч гаргасан гомдлыг өрсөлдөөний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага шүүхийн өмнөх шатанд урьдчилан хянан шийдвэрлэдэг байхаар хуулийн төсөлд тусгалаа.

¹ Үүнээс Монгол Улсын Шадар сайдын "Бүтэц батлах тухай" 2016 оны 103 тоот тушаал, агентлагийн даргын "Албан тушаалын жагсаалт батлах тухай" А/125 тоот тушаалаар 8 алба хаагч л Өрсөлдөөний тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах, бодлого боловсруулж хэрэгжүүлэх ажлыг улс орон даяар зохион байгуулан ажиллаж байна.

Хуулийн төслийн тавдугаар бүлэг:

Хуулийн төслийн энэ бүлэгт одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа Өрсөлдөөний тухай хуулийн зохицуулалтаас ялгаатай тусгагдсан зохицуулалт нь хөөн хэлэлцэх хугацааны талаархи асуудал байна.

Зөрчлийн тухай хуулийн 1.5 дугаар зүйлд хөөн хэлэлцэх хугацааг торгуулийн хэмжээнээс хамааруулан 6 сараас 2 жил хүртэл байхаар зохицуулсан. Мөн хөөн хэлэлцэх хугацааг өөр хуулиар тогтоосон бол тухайн хуулийг дагаж мөрдөнө гэж заасан байна.

Тиймээс Зөрчлийн тухай хуулийн дээрх зохицуулалтад нийцүүлэн Өрсөлдөөний тухай хуулийг зөрчсөн зөрчилд шалган шийдвэрлэх ажиллагаа явуулж болох хөөн хэлэлцэх хугацааг 3 жил байхаар хуулийн төсөлд тусгалаа.

Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу хуулийн төслийг боловсруулах хэрэгцээ, шаардлагын урьдчилсан тандан судалгаа, хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээ, дагалдах хуулийн төсөл, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог тус тус хийсэн болно.

Хуулийн төсөлд 4 зүйл, 21 хэсэг, 20 заалт шинээр оруулж, одоо мөрдөгдөж байгаа Өрсөлдөөний тухай хуулийн 2 бүлэг, 16 зүйл, 61 хэсэг, 43 заалтад өөрчлөлт оруулж, 1 зүйл, 11 хэсэг, 8 заалтыг хассан ба одоо мөрдөгдөж байгаа Өрсөлдөөний тухай хуулийн нийт заалтын 50-иас дээш хувьд нэмэлт өөрчлөлт орсон тул хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу шинэчилсэн найруулгын төсөл хэлбэрээр боловсруулсан.

Энэ хуулийн төсөлтэй холбогдуулан Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Банкны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төрийн хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Компанийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Өрсөлдөөний тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслүүд, "Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай" Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг тус тус боловсруулсан болно.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР